

**Аз жаргалтай хотын индекс сайжруулах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "б", 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

1.1. "Аз жаргалтай хотын индекс тооцох аргачлал"-ыг Үндэсний статистикийн хороогоор батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ү.Ганболд/-т,

1.2. "Аз жаргалтай хотын индекс тооцох аргачлал"-ыг нийслэл, дүүрэг, хорооны түвшинд тооцож, мониторинг хийх, аргачлалыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах төрийн бус байгууллагыг зохих журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах, шаардагдах хөрөнгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан "Аз жаргалтай хотын индекс тооцож, сайжруулах үе шаттай арга хэмжээний зардал"-аас гаргаж, гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т;

1.3. нийслэлийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Аз жаргалтай хотын индекс, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үр дүнтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг дүүрэг, хороодын Засаг дарга болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын дарга нарт;

1.4. Аз жаргалтай хотын индексийн шалгуур үзүүлэлтүүдийн дүнг нэгтгэн дүгнэж, жил бүрийн I улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлд танилцуулж байхыг Нийслэлийн Статистикийн газар (Ц.Заяхүү)-т.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД